



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 04 сарын 21 өдөр

Дугаар А/164

Арвайхээр

Г.Б.Рэнчинжагдагт буцалтгүй тусламж олгох тухай

Хөдөлмөрийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.3, Засгийн газрын 2019 оны “Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох” 7 дугаар тогтоолоор батлагдсан журмыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь;

1.Аймгийн Хөгжимт драмын театрт жижүүрээр ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэр тогтоолгох болсон тул Бадамгарав овогтой Рэнчинжагдагт 9024562 (есөн сая хорин дөрвөн мянга таван зуун жаран хоёр) төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламж олгосугай.

2.Дээрх буцалтгүй тусламжийн 9024562 (есөн сая хорин дөрвөн мянга таван зуун жаран хоёр) төгрөгийг орон нутгийн төсвийн тэтгэвэрт гарахад олгох тэтгэмжийн зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100347